



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 669

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 3 нэрийн, нийт 279,494,120.00 (хоёр зуун далан есөн сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга нэг зуун хорин) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 40,483,338.80 (дөчин сая дөрвөн зуун наян гурван мянга гурван зуун гучин найман төгрөг наян мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Х.Пүрэвжавд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006920
34-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 6 дугаар сарын 1-ны өдрийн
66 дугаар тогтоолын хавсралт

"ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ АШИГЛАЛТЫН
ХУГАЦАА СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Цаашид ашиглах хугацаа /жилээр/	Шинээр тогтоосон нэг бүрийн үнэ /төгрөг/	Шинээр тогтоосон нийт үнийн дүн /төгрөг/
1	Тоёото Ландкрузер 200, 0043 УБЯ	2011-01-01	1	102,219,120.00	3	24,532,588.80	24,532,588.80
2	Хюндай Старекс 89-46УНЯ	2012-05-01	1	37,300,000.00	3	8,952,000.00	8,952,000.00
3	Автозамын сүлжээний орон зайн мэдээллийн Arcgis систем		1	139,975,000.00	2	6,998,750.00	6,998,750.00
				279,494,120.00		40,483,338.80	
Нийт дүн				(хоёр зуун далан есөн сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга нэг зуун хорин)		(дөчин сая дөрвөн зуун наян гурван мянга гурван зуун гучин найман төгрөг наян мөнгө)	